


Монголын Уулчдын Үндэсний Холбооны
2016 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн
Удирдах зөвлөлийн хурлын 16/01 тоот
тогтооолын хавсралт

МОНГОЛЫН УУЛЧДЫН ҮНДЭСНИЙ ХОЛБООНЫ ДҮРЭМ

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

- 1.1. Монголын уулчдын үндэсний холбооны /цаашид "Холбоо" гэх/ нь Монгол оронд уулын спортыг хөгжүүлэх, түгээн дэлгэрүүлэх, түүний талаарх мэдлэг мэдээлэл болон олон улсын уулын спортын нийтлэг стандарт, дүрэм, хэм хэмжээг таниулан сурталчилах үндсэн зорилго бүхий уулын спортыг сонирхогч, хичээллэгч, мэргэжилтэн, дэмжигчдийн сайн дурын үндсэн дээр, хүсэл сонирхол, үйл ажиллагаагаа нэгтгэн чиглүүлэхээр байгуулсан, нийгэмд үйлчилдэг хуулын этгээдийн эрх эдэлж, үүрэг хүлээх, ашгийн бус, бие даасан, гишүүнчлэл бүхий нийгэмд үйлчилдэг төрийн бус байгууллага юм.
- 1.2. Холбоо нь Монгол Улсын Үндсэн Хууль, Төрийн бус байгууллагын тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомж, энэхүү дүрмийн хүрээнд үйл ажиллагаагаа явуулна.
- 1.3. Холбоо нь Монголын Үндэсний Олимпийн Хорооны гишүүн байх бөгөөд олимпизмын үзэл санааг тууштай дэмжиж, үйл ажиллагаанд нь идэвхтэй оролцно.
- 1.4. Холбооны үйл ажиллагаа нь ил тод, нээлттэй, тэгш эрх, хамтын удирдлагын зарчим дээр тулгуурлана.
- 1.5. Холбоо нь банкинд төгрөгийн болон валютын харилцах данстай байна
- 1.6. Холбоо нь үйл ажиллагааны онцлогийг илэрхийлсэн бэлгэдэл бүхий тэмдэг, тутай байж болно. Бэлгэдлийн загварыг удирдах зөвлөл батлана.
- 1.7. Холбоо нь хуулын этгээд мөн бөгөөд тогтоосон журмын дагуу үйлдсэн тэмдэг, албан бичгийн хэвлэмэл хуудас хэрэглэнэ.
- 1.8. Холбооны албан ёсны нэр нь:
 - Монгол хэлээр "Монголын Уулчдын Үндэсний Холбоо", товчоор "МУҮХ"
 - Англи хэлээр "Mongolian National Climbing Federation", товчоор "MNCF" байна.
- 1.9. Холбоо нь Олон Улсын Уулын Спортын Холбоо /UIAA/, Азийн Уулын Спортын Холбоо /UAAA/, Олон Улсын Спорт Авиалтын Холбоо /IFSC/-уудад Монгол улсыг төлөөлөн гишүүнээр элсэх ба, гадаад улсын уулын спортын холбоо, спортын бусад байгууллагуудтай уулын спорттой холбоотой чиглэлээр харилцаа тогтоож, гэрээ болон харилцан ойлголцлын санамж бичиг байгуулж, хамтран ажиллаж болно.
- 1.10. Холбоо нь Монгол Улсын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулах бөгөөд Холбооны оршин байх газар нь Улаанбаатар хот, Хан-уул дүүрэг, 1 дүгээр хороо, Монголын Үндэсний Олимпийн Хорооны байранд байрлана.
- 1.11. Холбооны байгуулгасан огноо: 1955 оны 06-р сарын 01-ний өдөр.
- 1.12. Холбоо нь орон нутагт өөрийн салбар, төлөөлөгчийн газар байгуулж болно.